

## МӨНГӨНИЙ ТОЙМ

2016 оны 12 дугаар сар

ХУРААНГУЙ:

- Мөнгөний нийлүүлэлт өмнөх сараас 3.0 хувь буюу 351.5 тэрбум төгрөгөөр өсч 12.1 их наяд төгрөгт хүрчээ. Үүнд М1 мөнгө 8.4 хувь, бусад хадгаламж, харилцах 1.9 хувиар өссөн нь нөлөөлөв.
- Мөнгөний бодлогын зөвлөлийн 2016 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хурлаар Бодлогын хүүг 1.0 нэгж хувиар бууруулж, 14.0 хувь болгох шийдвэр гаргасан.
- Тухайн сард Монгол улсын Хөгжлийн банк улсын байгууллагууд болон хувийн хэвшилд олгосон 3.2 их наяд төгрөгийн зээлийг Засгийн газарт шилжүүлсэнтэй холбоотойгоор санхүүгийн байгууллагуудын зээлийн үлдэгдэл буурч 16.3 их наяд төгрөг болов.
- Тайлант сарын эцэст санхүүгийн байгууллагуудын зээлийн 10.1 хувь нь хугацаа хэтэрсэн, 6.5 хувь нь чанаргүй гэж ангилагджээ.

МӨНГӨ, САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

		2014	2015	2016				
		12-р сар	12-р сар	3-р сар	6-р сар	9-р сар	11-р сар	12-р сар
<b>Инфляци</b>								
Улаанбаатар хотын	сарын	0.6	-0.2	0.3	-0.5	-0.9	0.7	0.9
	оны эхнээс	10.7	1.1	1.5	2.7	0.1	-0.4	0.5
	жилийн	<b>10.7</b>	<b>1.1</b>	<b>1.1</b>	<b>1.2</b>	<b>-0.7</b>	<b>-0.6</b>	<b>0.5</b>
Суурь	сарын	0.4	-0.1	-0.4	-0.1	0.3	1.0	0.3
	оны эхнээс	12.6	4.8	-1.1	-1.2	-1.0	0.2	0.5
	жилийн	<b>12.6</b>	<b>4.8</b>	<b>3.1</b>	<b>3.0</b>	<b>0.8</b>	<b>0.1</b>	<b>0.5</b>
Улсын	сарын	0.8	-0.2	0.5	-0.3	-0.6	0.5	0.7
	оны эхнээс	11.0	1.9	1.7	2.9	0.6	0.4	1.1
	жилийн	<b>11.0</b>	<b>1.9</b>	<b>1.7</b>	<b>1.6</b>	<b>-0.1</b>	<b>0.2</b>	<b>1.1</b>
<b>Мөнгө, санхүүгийн сектор</b>								
<b>Ноод мөнгө, сая ₮</b>		3,502.0	2,519.5	2,422.3	3,585.0	3,164.9	3,546.3	3,487.7
	сарын өөрчлөлт, хувиар	27.1	17.4	2.2	9.8	-4.8	20.9	-1.7
	жилийн өөрчлөлт, хувиар	5.0	-28.1	-4.9	47.5	27.1	65.2	38.4
<b>М2 мөнгө, сая ₮</b>		10,634.7	10,049.0	10,112.4	11,186.4	11,555.9	11,725.0	12,076.5
	сарын өөрчлөлт, хувиар	7.1	2.5	1.0	5.0	1.6	1.0	3.0
	жилийн өөрчлөлт, хувиар	12.5	-5.5	2.1	11.4	16.3	19.5	20.2
<b>Бусад хадгаламж, сая ₮</b>		8,817.9	8,363.6	8,528.7	9,204.2	9,535.3	9,796.4	9,986.4
	сарын өөрчлөлт, хувиар	7.0	1.4	0.5	3.3	1.5	2.9	1.9
	жилийн өөрчлөлт, хувиар	19.8	-5.2	0.9	9.9	14.6	18.8	19.4
<b>Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө, сая ₮</b>		809.7	706.7	658.6	839.2	795.8	768.7	823.6
	сарын өөрчлөлт, хувиар	5.3	-0.5	0.5	6.5	-2.6	-4.7	7.1
	жилийн өөрчлөлт, хувиар	-3.7	-12.7	-6.3	11.0	3.6	8.2	16.6
<b>Санхүүгийн байгууллагуудын зээлийн үлдэгдэл, сая ₮</b>		16599.5	17,932.8	18,430.3	18,410.2	19,240.1	19,747.2	16,256.2
	сарын өөрчлөлт, хувиар	2.7	0.5	1.5	1.7	0.6	1.4	-17.7
	жилийн өөрчлөлт, хувиар	31.2	10.9	11.5	8.1	8.0	10.7	-9.3
<b>Хадгаламжийн байгууллагуудын зээлийн үлдэгдэл, сая ₮</b>		12,503.5	11,706.6	11,835.5	12,030.4	12,490.9	12,718.5	12,422.2
	сарын өөрчлөлт, хувиар	-1.2	-1.6	1.7	5.1	0.4	1.2	-2.3
	жилийн өөрчлөлт, хувиар	16.1	-6.4	-3.6	0.6	4.6	6.9	6.1
<b>Хад. байгууллагуудын чанаргүй зээлийн үлдэгдэл, сая ₮</b>		625.7	869.8	967.9	1,035.6	1,119.3	1,167.0	1,051.7
	сарын өөрчлөлт, хувиар	0.9	0.5	6.2	-2.6	-0.6	2.4	-9.9
	жилийн өөрчлөлт, хувиар	10.6	39.0	37.7	33.8	31.3	34.8	20.9
<b>Мөнгөний үржүүлэгч</b>		3.04	3.99	4.17	3.12	3.43	3.65	3.96
<b>Хүү</b>								
<b>Хадгаламжийн ЖДХ</b>		12.5	13.3	13.3	13.3	13.2	13.3	13.1
	Хадгаламжийн бодит хүү*	1.8	12.2	12.2	12.1	13.8	13.9	12.6
<b>Зээлийн ЖДХ**</b>		19.5	19.1	19.7	19.1	20.1	20.6	19.7
	Зээлийн бодит хүү*	8.9	18.0	18.6	18.0	20.8	21.2	19.2
<b>Ипотекийн зээлийн хүү</b>		9.90	8.82	8.81	7.74	8.68	9.17	10.31
<b>ТБҮЦ-ны ЖДХ</b>		12.1	13.0	12.0	10.5	16.0	16.1	14.5
<b>Бодлогын хүү</b>		12.00	13.00	12.00	10.50	15.00	15.00	14.00
<b>БХЗ-ын ЖДХ</b>		12.20	11.84	12.55	11.33	15.87	15.96	15.51

\* Улаанбаатар хотын хэрэглээний барааны үнийн индексээр тооцсон

\*\* Төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү

### Мөнгөний нийлүүлэлт


Тухайн сард M2 мөнгөний нийлүүлэлт 3.0 хувь буюу 351.5 тэрбум төгрөгөөр өсч 12.1 их наяд төгрөгт хүрчээ. Үүнд M1 мөнгө 8.4 хувь, бусад хадгаламж, харилцах 1.9 хувиар өссөн нь нөлөөлөв.

M1 мөнгөний өсөлтөд төгрөгийн харилцах 129.5 тэрбум төгрөг, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 32.0 тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ. M1 мөнгөний M2 мөнгөнд эзлэх хувийн жин 17.3 хувьд хүрэв.

Бусад хадгаламж, харилцахын өсөлтөд төгрөгийн хадгаламж 3.1 хувь, гадаад валютын хадгаламж 4.1 хувиар өссөн нь нөлөөлөв. Үүнд иргэдийн хадгаламжийн өсөлт гол нөлөө үзүүлсэн байна. Тухайлбал, иргэдийн төгрөгийн хадгаламж 246.2 тэрбум төгрөг, гадаад валютын хадгаламж 109.5 тэрбум төгрөгөөр өсчээ.

Тухайн сард гадаад валютын харилцах 6.0 хувиар буурсан бөгөөд үүнд хувийн хэвшлийн гадаад валютын харилцах 154.1 тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлжээ. Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн өөрчлөлтийн нөлөөг хасч тооцвол гадаад валютын хадгаламж 3.1 хувиар өсч, гадаад валютын харилцах 6.9 хувиар буурсан байна.

Зураг 1. Мөнгөний нийлүүлэлтийн задаргаа




Зураг 2. Мөнгөний үзүүлэлтүүдийн сарын өөрчлөлт, тэрбум ₮



### Гадаад, дотоод актив

- Мөнгөний нийлүүлэлтийг байршуулалт талаас авч үзвэл, 2016 оны 12 дугаар сарын байдлаар хадгаламжийн байгууллагуудын гадаад цэвэр актив өмнөх сараас 338.8 тэрбум төгрөгөөр, дотоод цэвэр актив 690.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.
- Гадаад цэвэр активын өөрчлөлтөд банкуудын гадаад пассив 208.5 тэрбум төгрөгөөр буурч, гадаад актив 134.9 тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.
- Тайлант сард арилжааны банкуудын эзэмшиж буй Төв банкны үнэт цаас 169.6 тэрбум төгрөгөөр буурч, богино хугацаатай Засгийн газрын үнэт цаас 427.0 тэрбум төгрөгөөр өссөн байна. Энэ нь хадгаламжийн байгууллагуудын Засгийн


Зураг 3. Хадгаламжийн байгууллагуудын гадаад, дотоод цэвэр актив



газраас авах цэвэр авлага 447.6 тэрбум төгрөгөөр өсөхөд нөлөөлжээ.

- Тайлант сард банкуудын харилцах, хадгаламж 113.5 тэрбум төгрөгөөр буурсан нь нөөц мөнгө 58.6 тэрбум төгрөгөөр буурахад нөлөөлөв. Харин хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгө 32.0 тэрбум төгрөг, банкуудын касс дахь мөнгө 22.9 тэрбум төгрөгөөр өсчээ.

Зураг 4. Нөөц мөнгө




Санхүүгийн байгууллагын зээл

Санхүүгийн байгууллагуудаас олгосон зээлийн үлдэгдэл өмнөх сараас 3.5 их наяд төгрөгөөр буурч 16.3 их наяд төгрөг болжээ. Энэ нь Монгол улсын Хөгжлийн банк улсын байгууллагууд болон хувийн хэвшилд олгосон 3.2 их наяд төгрөгийн зээлийг Засгийн газарт шилжүүлсэнтэй холбоотой юм.


2016 оны 12 дугаар сарын эцсийн байдлаар санхүүгийн байгууллагуудын зээлийн 76.4 хувийг хадгаламжийн байгууллагууд, 23.6 хувийг бусад санхүүгийн байгууллагуудын олгосон зээл бүрдүүлж байна. Нийт зээлийн 48.1 хувийг иргэдэд, 45.4 хувийг хувийн хэвшилд, 6.5 хувийг улсын байгууллагуудад олгожээ.

Зээлийн үлдэгдэлд хугацаа хэтэрсэн зээлийн эзлэх хувь өмнөх сараас 1.2 нэгж хувиар буурч 10.1 хувь болжээ. Харин чанаргүй зээлийн хувь өмнөх сараас 0.6 нэгж хувиар өсч 6.5 хувьд хүрэв. Хадгаламжийн байгууллагуудын нийт зээлд хугацаа хэтэрсэн зээл 7.3 хувь, чанаргүй зээл 8.5 хувийг эзэлж байна. Татан буугдсан банкуудын мэдээллийг хасч тооцвол чанаргүй зээл 7.0 хувийг эзэлж байна.

Зураг 5. Санхүүгийн байгууллагуудын зээл



Зураг 6. Санхүүгийн байгууллагын хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээл



Мөнгөний зах

Тухайн сард банкууд банк хоорондын захаар дамжуулан 733.3 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн байна. Үүний 52.4 хувийг овернайт зээл, 21.5 хувийг репо арилжаа, 16.1 хувийг Төв банкны үнэт цаасны арилжаа, 10 хувийг банк хоорондын хадгаламж тус тус бүрдүүлжээ.

Банкууд 2016 оны 12 дугаар сарын 07-ноос 1 дүгээр сарын 3-ны өдрийн хооронд заавал байлгах нөөцийн шаардлага хангах зорилгоор 2407.6 тэрбум төгрөгийг Монголбанк дахь харилцах дансандаа төвлөрүүлжээ.

Зураг 7. Банк хоорондын захын арилжааны дүн, хүү




Хүү

Мөнгөний бодлогын зөвлөлийн 2016 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хурлаар Бодлогын хүүг 1.0 нэгж хувиар бууруулж, 14.0 хувь болгох шийдвэр гаргасан. Үүнтэй холбоотойгоор банк хоорондын захын хүү өмнөх сараас 0.5 нэгж хувиар буурч 15.51 хувь болжээ. Төв банкны үнэт цаасны жигнэсэн дундаж хүү өмнөх сараас 1.6 нэгж хувиар буурч 14.52 хувь болжээ.

Тайлант сард төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 0.2 нэгж хувиар буурч 13.1 хувь болжээ. Харин гадаад валютын хадгаламжийн хүү төдийлөн өөрчлөгдөөгүй бөгөөд 6.0 хувь байна. Тайлант сарын эцэст төгрөгийн харилцахын хүү 2.8 хувь, валютын харилцахын хүү 1.7 хувь байна.

Зураг 8. Хүү




Тухайн сард олгосон зээлийн жигнэсэн дундаж жилийн хүү өмнөх сараас 0.9 нэгж хувиар буурч 19.7 хувь болов. Харин зээлийн үлдэгдлээр жигнэсэн дундаж зээлийн хүү өмнөх сараас төдийлөн өөрчлөгдөөгүй бөгөөд 18.5 хувь байна.

Валютын ханш

Тайлант сарын эцэст Монголбанкнаас зарласан төгрөгийн ам.доллартай харьцах ханш 0.9 хувь буюу 22.9 төгрөгөөр суларч 2489.53 болжээ. Тухайн сард төгрөгийн ам.доллартай харьцах дундаж ханш 2482.57 төгрөг байв.

Тайлант сарын эцэст төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханшийн индекс 1.3 хувиар буурсан буюу төгрөгийн ханш суларсан байна.

Зураг 9. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн индекс, 2010.12.31 = 100




Инфляци

2016 оны 12 дугаар сарын инфляци улсын хэмжээнд 0.7 хувь байсны 0.5 нэгж хувийг хүнсний барааны үнийн өөрчлөлт, 0.2 нэгж хувийг хүнснээс бусад бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлт эзэлж байна. Тухайн сард хүнсний барааны бүлгийн үнэ 2.0 хувь, амралт, чөлөөт цагийн бүлгийн үнэ 0.7 хувь, тээврийн бүлгийн үнэ 0.5 хувь, хувцас, бөс барааны бүлгийн үнэ 0.4 хувиар өссөн байна.

Жилийн инфляци улсын хэмжээнд 2016 оны 12 дугаар сарын байдлаар 1.1 хувь гарсны 0.8 нэгж хувийг хүнснээс бусад бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлт бүрдүүлжээ. Хүнсний барааны жилийн инфляци 1.2 хувь байсан бол хүнснээс бусад, бараа үйлчилгээний инфляци 1.1 хувь байв.

Зураг 10. Улсын сарын инфляци



Зураг 11. Улсын жилийн инфляци

